

**ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДИЙН СОНГОГЧДЫН
НЭРИЙН ЖАГСААЛТ ҮЙЛДЭХ, ХҮРГҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэхэд энэ журмыг баримтална.

**Хоёр.Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах,
түүнд өөрчлөлт оруулах**

2.1.Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс 45 хоногийн өмнөөс эхлэн гадаад улсад санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө өөрийн байгаа улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт биечлэн, эсхүл шуудан, эсхүл цахим шуудангаар сонгуульд оролцохоо мэдэгдэж бүртгүүлнэ.

2.2.Гадаад улсад байгаа иргэн сонгуульд оролцохоор бүртгүүлэхдээ уг журмын хоёрдугаар хавсралтаар баталсан маягтын асуулгын дагуу үнэн зөв бичиж, үндэсний гадаад паспортын хуулбарын хамт Салбар комисст хүргүүлнэ.

2.3.Гадаад улсад байгаа иргэн сонгуульд оролцохоор бүртгүүлэх маягт нь дараах мэдээллийг агуулсан байна.

2.3.1.эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр;

2.3.2.төрсөн он, сар, өдөр, нас, хүйс;

2.3.3.үндэсний гадаад паспортын болон регистрийн дугаар/иргэний бүртгэлийн дугаар;

2.3.4.Монгол Улсын хилээр хамгийн сүүлд гарсан он, сар, өдөр;

2.3.5.эх орондоо оршин сууж байсан газрын хаяг;

2.3.6.одоо оршин сууж байгаа газрын хаяг /гадаад/;

2.3.7.сонгуулийн санал авах өдөр гадаад улсад байх эсэх.

2.4.Салбар комисс гадаад улсад байгаа сонгуульд оролцохоор бүртгүүлсэн иргэнийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгаж, сонгогчийн бүртгэлийн программд иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн мэдээллийн дагуу бүртгэнэ.

Иргэний мэдээлэл буруу буюу зөрүүтэйн улмаас бүртгэх боломжгүй тохиолдолд холбогдох иргэнд тухай бүр мэдээлж, зөрчлийг арилгуулсны дараа бүртгэлийг хөтөлнө.

2.5.Салбар комисс гадаад улсад байгаа иргэдийг бүртгэх ажиллагаа дуусмагц гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг Төв комисст нэн даруй хүргүүлнэ.

2.6.Төв комисс салбар комиссоос ирүүлсэн гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг тухай бүр улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ

2.7.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нягтлан шалгана.

2.8.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг Төв комиссоос холбогдох маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, тухайн сонгогчийн Монгол Улсад байнга оршин суугаа газрын хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасаж, “Тайлбар” хэсэгт “Гадаад улсад санал өгөхөөр бүртгэгдсэн” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийнэ.

2.9.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Төв комиссоос ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгасны дараа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар салбар комисс тус бүрээр сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хэлбэрээр үйлдэж, Төв комисст хүргүүлнэ.

2.10.Гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгахтай холбоотой үйл ажиллагааг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж хариуцна.

Гурав.Бусад

3.1.Төв болон Салбар комисс нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хадгаламжийн нэгж болгон бүрдүүлж, Архив, албан хэрэг хөтлөлтийн журамд заасны дагуу холбогдох байгууллагад дагуу хүлээлгэн өгнө.

3.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.